



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ХЭРЛЭН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 01 сарын 20 өдөр

Дугаар 7/15

Чингис хот

Захиалагчийг төлөөлж гүйцэтгэлийг хянан
баталгаажуулах албан тушаалтныг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Сангийн сайдын 282 дугаар тушаалын 5 дугаар зүйлийн 5.2 дахь заалт, 9 дүгээр зүйлийн 9.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

1.Сумын хэмжээнд Улсын болон орон нутгийн төсөв, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэх ажлын батлагдсан зураг төсөл болон төсөв, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээнд тусгасан ажлын үе шатны хуваарийг төсөл, арга хэмжээ бүрээр гүйцэтгэлийг хянан баталгаажуулах албан тушаалтныг доорх бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Захиалагчийг төлөөлж:	Засаг даргын Тамгын газрын дарга Санхүү албаны дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч Холбогдох нягтлан бодогч Дэд бүтэц хариуцсан мэргэжилтэн
Зөвшилцсөнөөр:	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын Барилга хот байгуулалтын хэлтсийн хяналтын дарга Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын барилгын асуудал хариуцсан мэргэжилтэн Зураг төсөл зохиогч

2.Энэхүү захирамжийн биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын орлогч дарга (А.Боргил)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ЭРДЭНЭБААТАР